



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/08

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан Албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж (Санхүүгийн хяналт, аудитын алба)-ийн ажлын даалгавар бэлэн болсон тул ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Сүхнаран (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Батсүх (Төрийн байгууллагын төлөөлөл)

Д.Даваасүрэн (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Н.Мөнхдалай (Иргэний төлөөлөл)

Нарийн

бичиг: Г.Азсайхан (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Сүхнаран)-д даалгасугай.

8400003 0138

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Г.Азсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БААСАНХҮҮ

